

“Хамтын бүтээлч үйл ажиллагаа төвтэй хичээлийн судалгаагаар багш хөгжих нь”

Дорнод аймгийн боловсролын газрын байгалийн ухааны боловсрол хариуцсан мэргэжилтэн Х.Баясгалан

Судалгааны сэдэв: “Сурах- сургах” арга зүйн шинэчлэл”

Сэдэв сонгосон шалтгаан: Хүн төрөлхтөн тасралтгүй суралцаар, сурч мэдсэнээ хэрэгжүүлсээр, тэр нь хөгжил өөд хөтөлсөөр ирсэн. “Хичээлийн судалгааны арга зүйд” суралцаж, хэрэгжүүлж, алдаа оноогоо цэгнэн, сайжруулахын төлөө хамтдаа зүтгэсэн он жилүүд бол “Багшийн хөгжил-суралцагчийн хөгжил”-д нэн чухал хувь нэмрээ оруулсан, цаашид энэ арга зүйг багш бүхэн хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга зүйнхээ “үндэс” болгон илүү ихээр суралцаж, боловсронгуй болгох зорилгоор санал, бодлоо солилцох, хамтарч ажиллах хүслээр энэхүү сэдвийг сонголоо.

Сэдэв сонгосон үндэслэл: Багшийн хөгжил-суралцагчдын хөгжил-сургуулийн хөгжил-боловсролын хөгжил

Ерөнхий танилцуулга

Судалгааны зорилго: Багш нар хамтран ээлжит хичээлийн хөтөлбөрөө боловсруулах, хичээлээ зааж турших, засан сайжруулах, “Хичээлийн судалгаа”-ны арга зүйд суралцах түгээн дэлгэрүүлэх, хүүхдийн хөгжилд гарч байгаа ахиц өөрчлөлтийг тооцох

Ерөнхий боловсролын 7-9 дүгээр ангийн хими, физик, газарзүй, биологийн хичээлүүдийг судлагдахуунаар сонгосон ба хуваарийн дагуу сар бүр нэг сургуульд судалгаат хичээл зохион байгуулан, хичээлийн хэлэлцүүлэг хийж, сургалтын хөтөлбөрөө сайжруулан ажилласан юм.

7-9 дүгээр ангийн 456 сурагчид судалгаат хичээлд хамрагдаж, хими, биологи, физик, газарзүйн мэргэжлийн 59 багш нар 9 удаа оролцлоо.

Хуваарийн дагуу байгалийн ухааны багш нарын нэг нь / зарим сургуульд 4 мэргэжлийн багш нар тус бүрдээ / хичээлийн бэлтгэл судалгааг багаар хийж ээлжит хичээлээ зааж байсан ба сургууль бүр дээр бусад сургуулиудаас дээрх 4 мэргэжлийн багш нар очиж байгаа тул өөр өөрийн мэргэжлээр оролцох боломж бүрддэг.

Хугацаа: 2011-2012, 2012-2013 оны хичээлийн жил Сургууль дээр зохион байгуулж байгаа судалгаат хичээлийг хоёр хэлбэрээр явуулсан ба нэгдүгээрх нь өмнө засан сайжруулсан хөтөлбөрөөр хичээл заах, нөгөө нь хамтран боловсруулсан шинэ хөтөлбөрөөрөө хичээл заах, хэлэлцүүлгийн үр дүнд сайжруулах.

Судалгаат хичээлийг дараах төлөвлөгөөний дагуу зохион байгуулахад 30 хоногт багш нар хичээлийн төлөвлөлтөө боловсруулах, паралелль ангидаа зааж турших, бусад багш нарын санааг сонсох, хэрэглэгдэхүүнийг оновчтой сонгож, хэрэглэх, хичээл заах ангийн сурагчдаа нарийн судлах / өмнөх мэдлэг болон өмнөх төсөөллийг харж чаддаг болох /гэх мэт сайн үр дүн гарах боломж бүрддэгийг судалгааны явцад харсан юм. Хуваарийг хичээлийн жилийн эхэнд сургууль бүрд хүргүүлдэг учир тухайн өдрийн хичээлд зохицуулалт хийж багш нарыг бүрэн хамруулах боломж бүрдүүлдэг.

Хичээлийн судалгаа	Сургууль	I	II	V	Хан-Уул	VI	Шинэ хөгжил	VIII	XI	XII
	Сар	9	10	11	12	1	2	3	4	5
	Сар бүрийн 2 дахь 7 хоногийн баасан гарагт 14,00 цагаас									

Үйл ажиллагаа:

- “Хичээлийн судалгаа”-ны багаар хамтран сургалтын хөтөлбөр боловсруулах- хичээлийн бэлтгэл судалгаа
- Паралелль ангид заах, хэлэлцүүлэг хийж, хөтөлбөрөө сайжруулах
- Хуваарьт өдрөө зааж, бусад сургуулийн багш нар ажиглах, хэлэлцүүлэг хийж, санаа бодлоо солилцох, дараагийн ажлаа төлөвлөн хэлэлцэх, шинэ санааг тэмдэглэх / хичээл ажиглах, хэлэлцүүлэгт оролцох багш нэг бүрийг үүрэгжүүлэн ажлыг хуваарилах /
- Хөтөлбөрийг засан сайжруулах, шинэ санааг тусган хэрэгжүүлэх боломжийг судлах
- Сурагчдад гарч байгаа ахиц өөрчлөлтийн судалгаа

- Багшийн хөгжилд гарч байгаа ахиц өөрчлөлтийн судалгаа

Сурагчдын хөгжилд гарч байгаа өөрчлөлт

Бидний хамтын ажиллагааны гол зорилго бол “Сурагчид байгалийн ухааны хичээлүүдээр таамаглал дэвшүүлэх, туршиж үзэх, өөрийн биеэр хийж, ажиглах, хийж бүтээсэн талаараа бусаддаа тайлбарлах, дэвшүүлсэн таамаглал хэр үндэслэлтэй болсонд дүгнэлт хийж, хийж байгаа үйлдлүүдээ тэмдэглэж, зураглаж, график байгуулж сурах, харилцан суралцах **аргад сургах** явдал байсан бөгөөд багш бүр дээрх чиглэлээр ажиглалт хийсэн нь эргээд багш нар хүүхдийг хэрхэн судлах, ахиц өөрчлөлтийг тооцож сурах, өөрийн хийж байгаа үйл бүхнээ дүгнэх аргад суралцуулдагаараа онцлог байлаа. Үүний үр дүнд сурагчид:

- Судлах гэж байгаа агуулгынхаа учир шалтгааныг ойлгох
- Туршилт судалгаа хийхийн өмнө таамаглал дэвшүүлэн, өөрийн санаагаа туршиж үзэх
- Туршилтын үед ажиглалтыг нарийн хийж, гол зүйлээ тэмдэглэх
- Багаар хамтран ажиллах, бусдын дэмжлэлийг авч сурах
- Бүтээлч байдал бий болж, мэдээлэл цуглуулах, дүгнэлт гаргах, бусаддаа тайлбарлах, нотлох
- Цаашид үргэлжлүүлэн судлах, учир шалтгааныг бүрэн тодорхойлох хүсэл тэмүүлэл бий болох зэрэг өөрчлөлтүүдийг багш нар ажиглан судлаж байна.

Багшийн хөгжил, арга зүйд гарч байгаа өөрчлөлт

- “Хичээлийн судалгаа” нь багш нарын хамтын бүтээлч үйлээр ажлын байран дээрээ **хамтран хөгжих арга** юм гэдэгтэй багш бүр санал нийлсэн
- Хичээлийг хүнд үзүүлэхийн тулд биш, арга зүйгээ сайжруулахын тулд тогтмол хийж сурах, хүүхдийн хөгжлийг ажиглах, ахиц өөрчлөлтийг нь тооцох, багш хийж байгаа ажилдаа урам зориг орж, цаашид улам боловсронгуй болгох хэрэгтэйг тогтоосон
- Хичээлийн бэлтгэл судалгааг хэрхэн хийснээс цаашдийн бүх үйл ажиллагаа хамааралтай болохыг мэдэрсэн
- Хүүхэд нэг бүртэй ажиллах аргачлал боловсруулан, тэдний чадварт тулгуурласан арга зүйг хэрэгжүүлэх нь чухал болохыг ойлгосон
- “Олны хүч оломгүй далай”, хамтаараа хэлэлцэж, санал бодлоо солилцож боловсруулсан арга зүй нь дээрх үйлүүдийг хэрэгжүүлэхэд үр дүнтэй болохыг ухаарч багш нар хамтын, бүтээлч үйл ажиллагааг эрхэмд үзэх хандлага бий болсон явдлыг багшийн хөгжилд гарч байгаа нэг ахиц гэж үзэж байна.

Бие биенээсээ хэрхэн суралцсан тухай

Байгалийн ухааны багш нар 5 секцэд хуваагдан өөр өөрийн мэргэжлийн чиглэлээр судалгаат хичээлийг зохион байгуулахын тулд

- Тухайн агуулгын шинжлэх ухааны онолын талаар
- Стандартыг хэрэгжүүлэхэд оруулах хувь нэмэр
- Ямар чадварыг хэрхэн төлөвшүүлэх талаар
- Арга зүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээ, судалгааны ажлын талаараа суралцаж хамтран ажилладаг

Багш нар бие биенээсээ харилцан суралцахаас гадна манай аймагт 2012 оны 08 сараас 2013 оны 03 сард Японы сайн дурын гишүүн, байгалийн ухааны багш Хирано Тэрүми ажиллаж багш бүртэй хамтран хөтөлбөр боловсруулах, хичээл заах, ажиглах, хэлэлцүүлэг зохион байгуулах, энэ үед багш нэг бүрийн үүрэг хариуцлага, дараа нь үр дүнгээ хэрхэн тооцох талаар зөвлөгөө өгч ажилласан нь багш нарыг хамтран бүтээлчээр ажиллахад суралцуулсан ажил болсон.

Сайн тал

- Багш нар ажлын байрандаа арга зүй, ур чадвараа дээшлүүлэн хүүхдийг хөгжүүлэх, дэмжих аргачлал боловсруулагдан урам зоригтой, үүрэг, чиглэлтэй, арга зүйн шинэчлэл тодорхой зорилготой хийгдэж байна
- Бусад мэргэжлийн багш нар “хичээлийн судалгаа”-ны арга зүйг судлах, эзэмших, туршиж үзэх санаа сэдэл төрж бүх сургуулиуд төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн
- Сургуулийн удирдлага “хичээлийн судалгаа”-ны сайн талыг бүрэн ойлгож, дэмжлэг үзүүлэн хамтран оролцдог, илүү үр бүтээлтэй ажиллаж байгаа багш нараа урамшуулан дэмждэг, бүтээл гаргадаг, сан бүрдүүлдэг, туршлага бий болгодог, түгээн дэлгэрүүлдэг болсон нь бүх сургуулиудад үлгэр болж суралцах, туршихыг эрмэлзэх хүсэл бий болгосон
- Эцэг эх, асран хамгаалагчид “хичээлийн судалгаа”-ны талаар мэдлэгтэй болж сургууль багш нарт дэмжлэг үзүүлэх, судалгаат хичээлд оролцохоос гадна, хүүхдийнхээ үйл ажиллагааг дэмжин туслах хандлага бий болж эхэлсэн

Сул тал

“Хичээлийн судалгаа”-ны арга зүй нь өөрөө багш, сурагчдын хөгжлийн үндэс, хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд хэрэглэж болох “түлхүүр” болохынхоо хувьд багш бүр сэтгэлээсээ хандах л сул тал

гаргахгүй ажиллах шалтгаан болно.

Үнэлгээ

- Байгалийн ухааны мэргэжлийн 5 хичээлийн багш нар “Хичээлийн судалгаа”-ны арга зүйд суралцан, эзэмшиж, амжилттай хэрэгжүүлж эхэлсэн ба цаашид суралцах, боловсронгуй болгох, хүүхдээ судлах ажлуудыг нарийвчлан хийхээр төлөвлөж байна
- Сургууль бүр дээр байгалийн ухааны мэргэжлийн хичээлүүдийн сайжруулсан хөтөлбөрийн сан бүрдэж, хэрэглэгдэж байна
- “Хичээлийн судалгаа”-ны арга зүйг эзэмшиж, туршиж, үр дүнгээ тооцож ажилласан багш нар аймаг, бүсийн сургагч багш нар болж, бүсийн хэмжээнд 2 удаа, аймагт 4 удаа сургалт зохион байгуулсан ба бүсийн хэмжээнд мониторинг хийхэд оролцлоо.
- Загвар сургуулийн байгалийн ухааны багш нар “Хичээлийн судалгаа”-ны гарын авлага бүтээн арга туршлагаа түгээн дэлгэрүүлж байна.

Үр дүнтэй болсон эсэхийг шинжлэх

“Хичээлийн судалгаа”-г багш бүрийн арга зүйн шинэчлэлийн үндэс болгож, энэ аргыг бүтээлч, идэвхтэй үйлээр хэрэгжүүлснээр гарах үр дүнг тооцох “Сурах- сургах арга зүйн шинэчлэл” сэдвээр судалгаа хийгдэж байна.

Үр дүн

Багш нар хамтран ажиллах төлөвлөлтийг сайн хийж, сургуулийн удирдлагууд дэмжин, энэ л бидний эзэмших, хэрэгжүүлэх, хөгжих, судлах гол зүйл юм гэдгийг ойлгуулснаар үр дүн гарч эхэлсэн.

Бидний хамтын ажиллагааны туршлага нээлттэй, бидэнд бусдаас суралцах зүйл ч их байна.

Цаашид хөгжүүлэх санал

- Аймгийнхаа бүх багш нарын хүртээл болгож, төв хөдөөгүй ижил түвшинд хөгжих
- Аймаг бүсийн хэмжээнд багш нарын гаргасан туршлагуудыг судлах, хэрэгжүүлэх
- “Хичээлийн судалгаа”-ны талаарх олон улсын туршлагыг судлан, хэрэгжүүлэх
- Багш, сурагчдын хөгжлийг дэмжсэн олон аргуудтай хослуулан харилцан уялдаа холбоотойгоор арга зүйгээ боловсруулан туршиж үр дүнг тооцох

Дүгнэлт

БСШУЯ, ЖАЙКА байгууллагаас хамтран 2006 оноос хэрэгжүүлсэн “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төслийн загвар аймгаар сонгогдон суралцаж, судлаж, туршиж, хэрэгжүүлсэн туршлага, төслийн хоёр дахь шатанд хэрэгжсэн “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” төслийн түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаанд оролцож суралцсан аргууддаа үндэслэн байгалийн ухааны багш нар ажлын байрандаа хамтран хэрхэн хөгжих боломж байна?, түүгээрээ дамжуулан хүүхдийг хөгжүүлэх арга зүйгээ боловсруулах аргыг багш бүхэнд бий болгох зорилгоор “багийн зохион байгуулалтад шилжиж, хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлснээр” гарсан ахиц өөрчлөлтийн талаар товч дурьдлаа.

Хоёр үе шаттай хэрэгжсэн дээрх төслүүд нь “суралцахуйд суурилсан багшлахуйн” арга зүйн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан бөгөөд боловсролын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэгч багш нарын “оюун санаанд, сэтгэлгээнд, үйл ажиллагаанд, нүдэнд ” гүнзгий өөрчлөлт оруулсан хэмээн дүгнэж байна.